

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**



ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

Тендер шалгаруулалтын нэр:

**Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт
2023 онд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар:

ННҮГ/202302001

**Улаанбаатар хот
2023 он**

1. ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хүнсний бүтээгдэхүүн худалдан авах” тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүллээ.

Үнэлгээний хороо нь Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын зоогийн газарт хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх тухай захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр нээлттэй тендерийг зарлан тендерийн урилгыг тендер шалгаруулалтын хугацаанд www.tender.gov.mn цахим хуудсанд ил тодоор байршуулсан.

2. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-г үндэслэн нээлттэй тендер шалгаруулалтын журмаар бараа худалдан авахад ашиглах үнийн санал авах жишиг баримт бичгийг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулсан.

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/” болон “Тендерийн үнэлгээний заавар /цаашид Тендерийн үнэлгээний заавар гэх/”-ын дагуу үнэлсэн.

3. ТЕНДЕР ЗАРЛАХ БА ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

Тендерийн баримт бичгийг ажлын даалгаврыг үндэслэн үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэн боловсруулж, 2023 оны 04 дугаар сарын 18-ний өдөр Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын /цаашид ННҮГ гэх/ даргаар батлуулсан. Уг арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр тендерийг хүлээн авч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг үндэслэн хянан үзэхэд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул үнэлгээний хорооны шийдвэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн бүх тендерээс татгалзсан.

4. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА

Тендер шалгаруулалтын нээлт хийхээс өмнө тендер оролцогч нь 2023 оны 05 сарын 09, 11-ний өдрүүдэд тодруулга ирүүлснийг 2023 оны 05 сарын 12-ны өдөр тодруулгын хариуг Tender.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

5. ТЕНДЕРИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА БА ХААХ ӨДӨР

Тендер нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” /цаашид “хууль” гэх/-ийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасны дагуу тендер нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерийн материалыг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 14 цаг 00 минут хүртэл хүлээн авч мөн өдрийн 14 цаг 35 минутад нээлт хийсэн болно. Тендерийн хүчинтэй байх хугацаа 2023 оны 04 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдөр дуусна. Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

6. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ ИРҮҮЛЭХ БА НЭЭХ ӨДӨР

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хүнсний бүтээгдэхүүн худалдан авах тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 14 цаг 35 минутад нээхэд уг тендер оролцогч компани тендерийн материал ирүүлсэн байсан.

7. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

Эрх бүхий эсэх

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 Монгол улс, эсхүл үүсгэн байгуулсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй

Гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх

Хуулийн 15 зүйлийн 15.3.4 дахь заалтыг үндэслэн ТШЗ 18.2: Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудын борлуулалтын орлого нь тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна гэсэн шаардлагад нийцсэнгүй.

Хуулийн 15 зүйлийн 15.3.2 дахь заалтыг үндэслэн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс 2023-05-19-ны өдрөөр мэдээллийг шалгахад 2022 оны цахим баталгаажсан тайлан ирүүлээгүй нь шаардлагад нийцсэнгүй

8. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ТЕНДЕР ИРҮҮЛСЭН ЭСЭХ

Дээрх шаардлагуудыг хянан үзэхэд шаардлагад нийцсэн тендерийн материал ирүүлэгүй.

9. ТЕНДЕРИЙГ НАРИЙВЧЛАН ХЯНАН ҮЗЭХ

Хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

Эрх бүхий эсэх

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 Монгол улс, эсхүл үүсгэн байгуулсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй

Гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх

Хуулийн 15 зүйлийн 15.3.4 дахь заалтыг үндэслэн ТШЗ 18.2: Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудын борлуулалтын орлого нь тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна гэсэн шаардлагад нийцсэнгүй.

Хуулийн 15 зүйлийн 15.3.2 дахь заалтыг үндэслэн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс 2023-05-19-ны өдрөөр мэдээллийг шалгахад 2022 оны цахим баталгаажсан тайлан ирүүлээгүй нь шаардлагад нийцсэнгүй

9.1. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БУЮУ ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ ТООЦОХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт болон тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох заалтын дагуу тус тус хянан үзэхэд үнийн хөнгөлөлт тооцохоор үнийн санал ирүүлээгүй болно.

9.2. ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ТООЦОХ

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт болон холбогдох нотлох баримтыг үндэслэн хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 81 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг мөрдлөг болгон дотоодын давуу эрхийн зөрүүг тооцуулах хүсэлтийг тендерт оролцогчид ирүүлээгүй учир тооцоогүй болно.

10. ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь ННҮГ/202302001 дугаартай “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хүнсний бүтээгдэхүүн худалдан авах” тендерийн гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг үнэлж сонгон шалгаруулахад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй байна.

ННҮГ/202302001 дугаартай Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо

тендер шалгаруулалтын үнэлгээг хийж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй байсан тул дахин зарлах.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**



ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

Тендер шалгаруулалтын нэр:

**Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт
2023 онд ахуйн цэвэрлэгээний материал
худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар:

ННҮГ/202302002

**Улаанбаатар хот
2023 он**

1. ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт 2023 онд ахуйн цэвэрлэгээний материал худалдан авах” тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүллээ.

Үнэлгээний хороо нь Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт ахуйн цэвэрлэгээний материал нийлүүлэх тухай захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр нээлттэй тендерийг зарлан тендерийн урилгыг тендер шалгаруулалтын хугацаанд www.tender.gov.mn цахим хуудсанд ил тодоор байршуулсан.

2. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-г үндэслэн нээлттэй тендер шалгаруулалтын журмаар бараа худалдан авахад ашиглах үнийн санал авах жишиг баримт бичгийг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулсан.

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/” болон “Тендерийн үнэлгээний заавар /цаашид Тендерийн үнэлгээний заавар гэх/”-ын дагуу үнэлсэн.

3. ТЕНДЕР ЗАРЛАХ БА ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

Тендерийн баримт бичгийг ажлын даалгаврыг үндэслэн үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэн боловсруулж, 2023 оны 04 дугаар сарын 21-ний өдөр Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын /цаашид ННҮГ гэх/ даргаар батлуулсан. Уг арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр тендерийг хүлээн авч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг үндэслэн хянан үзэхэд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул үнэлгээний хорооны шийдвэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн бүх тендерээс татгалзсан.

4. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА

Тендер шалгаруулалтын нээлт хийхээс өмнө тодруулагын хүсэлт ирүүлээгүй

5. ТЕНДЕРИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА БА ХААХ ӨДӨР

Тендер нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” /цаашид “хууль” гэх/-ийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасны дагуу тендер нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерийн материалыг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 14 цаг 00 минут хүртэл хүлээн авч мөн өдрийн 14 цаг 35 минутад нээлт хийсэн болно. Тендерийн хүчинтэй байх хугацаа 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр дуусна. Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

6. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГИЙГ ИРҮҮЛЭХ БА НЭЭХ ӨДӨР

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хүнсний бүтээгдэхүүн худалдан авах тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 14 цаг 35 минутад нээхэд уг тендерд 3 оролцогч компани тендерийн материал ирүүлсэн байсан.

7. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

Эрх бүхий эсэх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хуулийн 16 дүгээр зүйлийн 16.1.6 мөн 16.1.3; 16.1.7; 15.3.2 заалтуудыг үндэслэн шаардлагад нийцсэнгүй.

8. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ТЕНДЕР ИРҮҮЛСЭН ЭСЭХ

Дээрх шаардлагуудыг хянан үзэхэд шаардлагад нийцсэн тендерийн материал ирүүлэгүй.

9. ТЕНДЕРИЙГ НАРИЙВЧЛАН ХЯНАН ҮЗЭХ

Хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

Эрх бүхий эсэх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хуулийн 16 дүгээр зүйлийн 16.1.6 мөн 16.1.3; 16.1.7; 15.3.2 заалтуудыг үндэслэн шаардлагад нийцсэнгүй.

9.1. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БУЮУ ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ ТООЦОХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт болон тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох заалтын дагуу тус тус хянан үзэхэд үнийн хөнгөлөлт тооцохоор үнийн санал ирүүлээгүй болно.

9.2. ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ТООЦОХ

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт болон холбогдох нотлох баримтыг үндэслэн хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 81 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг мөрдлөг болгон дотоодын давуу эрхийн зөрүүг тооцуулах хүсэлтийг тендерт оролцогчид ирүүлээгүй учир тооцоогүй болно.

10. ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь ННҮГ/202302002 дугаартай “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт ахуйн цэвэрлэгээний материал худалдан авах” тендерийн гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг үнэлж сонгон шалгаруулахад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй байна.

ННҮГ/202302002 дугаартай Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт ахуйн цэвэрлэгээний материал худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй байсан тул дахин зарлах.